

Онгон сумын ИТХ, Засаг даргын тамгын газрын

2021.01 дугаар сарын мэдээ

Нэг: Удирдлага зохион байгууллатын чиглэлээр.

Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

- ✓ Сумын ИТХурал 2 удаа хуралдаж төсөв санхүү, ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг батлан гаргалаа. Тэргүүлэгчдийн хурал 4 удаа хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа.
- ✓ Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд ажиллаа. Ажиллах үеэрээ төсөвт болон төрийн өмчит 6 байгууллага, хилийн дугаар ангид ажиллаж ажилтан албан хаагчидтай уулзаж нийт 43 төрлийн чиглэлээр үүрэг өгсөн.
- ✓ Цар тахлын үед Хандиваар 6.350.000 төгрөг хандиваар, төсвөөс 4.200.000 төгрөгийг зарцуулсан байна.

Хоёр: Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд.

- ✓ Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг хэрэгцээт үед нь тогтмол гарган өгч байна.
- ✓ Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй болон ажиллаа.
- ✓ Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгч байна.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд.

- ✓ ИТХурал, ЗДТГазраас Хог хаягдлын хураамж батлах тухай шийдвэрийг хууль зүй дотоод хэргийн яамаар хянуулж бүртгүүлээ. Малын тоо толгойн албан татварын тогтоолын төслийн хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.
- ✓ Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж хуулийн дагуу аймгийн ХОХБТХэлтсээр хянуулан дүгнэлт гаргуулж дүгнэлтийн дагуу өөрчлөлт хийж ИТХ-аар батлууллаа.

Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

- ✓ Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд 2 дугаар сарын 1 нээс төгсөх ангийн сурагчдад танхимаар давтлага өгөх ажлыг зохион байгуулахаар болоод байна. Нийт 42 сурагчидад нэг ангид 17 хүүхэд байхаар тооцож давтлагын ажил эхлээд байна.
- ✓ Сумын амьжиргаа дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж 8 иргэний материал хэлэлцлээ.

✓ Сум дундын эмнэлэгээс гэрийн ажиглалтанд он гарсаар 36 иргэнд тухай бүр ажиглалт тандалт хийж ажиллаа.

✓ 01 дүгээр сарын 07-ний өдөр ойрын хавьтагч тус суманд ирсэн тухай мэдээллийн дагуу нийт 35 албан хаагч 4 тээврийн хэрэгсэл 72 цагийн хугацаатай үүрэг гүйцэтгэсэн.

✓ Хүн ам 3868 үүнээс эрэгтэй 1948, эмэгтэй 1920. Нийт хүн амын 49,64 хувь нь эрэгтэй, 50,36 хувь нь эмэгтэйчүүд эзэлдэг. Гадаадад 12 иргэн амьдарч байна. Нийт хүн амын 1369 нь 18 хүртэл насны, 427 нь 55 дээш насны иргэд байна.

✓ Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Нийт тоологдсон малын тоо-342129, өмнөх оны мөн үеийнхээс 10482 тоо толгойгоор өссөн.

Үүнээс: Тэмээ-804- 790 /-14/

Адуу- 19608 -19693 /+85/

Үхэр- 23169 – 25037 /+1868/

Хонь- 196542 – 201736 /+5194/

Ямаа- 91524 – 94873 /+3349/

✓ Хөдөө аж ахуйн өвөлжилт хүндэрч сумын баруун урд тал, баруун тал, баруун хойд тал бүхэлдээ цасны зузаан нягтрал нэмэгдэж бог мал муудаж эхлээд байна. Сумын ЗДТГазрын ХААТасгаас аймгийн ХХААГазарт 1000 боодол өвсний захиалга хүргүүлээд байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.АДЪЯА